

Намтар/CV загвар

Загварыг ашиглахдаа 1-15-р асуултад илүү анхаарна уу. Асуултын доорх дэд хэсгүүдийг жишээ, тайлбар байдлаар үзүүлсэн болно.

1. Хувийн мэдээлэл болон CV-ний огноо

- Овог нэр
- Өөрийн нэр
- Судлаачийн ID (жишээ нь: **ORCID**, **ResearcherID**)
- CV бэлтгэсэн огноо

2. Боловсролын болон эрдмийн зэрэг

- Зэрэг олгосон диплом, гэрчилгээний огноо (хамгийн сүүлийнхийг эхэнд нь), зэргийн нэр, голлох мэргэжлийн чиглэл/зэргийн хөтөлбөр, эсвэл түүнтэй адилтгах хөтөлбөр, боловсролын байгууллагын нэр, байрлаж буй хот, улсын нэр; зэрэг олгосон байгууллагын холбоо барих албан ёсны хаяг;
- Эрдмийн цолны нэр: гэрчилгээ олгосон огноо, судалгааны чиглэл, их сургууль.

3. Бусад боловсрол, мэргэшил

- Бусад боловсрол, мэргэжлийн үр чадвар/мэргэшсэн байдал
- Нэмэлт сургалт: төгссөн огноо, сургалтын нэр, боловсрол, сургалт явуулсан байгууллага, хамрах хүрээ (нэр болон нутаг дэвсгэр)

4. Хэлний чадвар

- Төрөлх хэл
- Бусад хэлний мэдлэг: хүрсэн түвшин, гэрчилгээ авсан огноо, эсвэл үр чадварын өөрийн үнэлгээ

5. Одоогийн ажил эрхлэлт

- Хөдөлмөрийн харилцааны эхэлсэн, дуусгавар болсон огноо, одоогийн албан тушаалын нэр, ажил олгогч болон ажлын байр (хэрэв цагийн ажил бол энэ тухай, шаардлагатай бол ажлын байрны товч тодорхойлолтыг хавсаргана)
- Эрдэмтэн судлаачийн дэвшлийн үе (**stage of academic research career**). Дөрвөн шатлалт (I–IV) судлаачийн дэвшлийн загвар (R1: Анхлан судлаач, R2: Танигдсан судлаач, R3: Батлагдсан судлаач, R4: Тэргүүлэх судлаач).
- Бүтэн цагийн оюутны хувьд: боловсролын байгууллага (нэр, нутаг дэвсгэр) болон зэргийн нэр, зэрэг олгох хөтөлбөр эсвэл түүнтэй адилтгахуйц
- Хоёрдогч ажил, мэргэжил

6. Өмнөх ажлын туршлага

- Өмнөх хөдөлмөрийн харилцаа, тэтгэлгийн хугацаа (хамгийн сүүлийнх нь эхэнд), урт хугацааны гадаад зочлол: ажил/үүргийн эхэлсэн, дуусгавар болсон огноо, албан тушаалын нэр, ажил олгогч, ажлын байр эсвэл санхүүжүүлэгч байгууллага (хэрэв хагас цагийн ажил бол үүнийг тусгах, шаардлагатай бол ажлын товч тодорхойлолт)
- Өмнөх хоёрдогч ажил, мэргэжил болон өргөдөлд хамааралтай бусад албан тушаал, хүлээсэн үүрэг, харилцаа (жишээ нь: компанид)

7. Ажлын завсарлага

- Энэ мэдээллийг сайн дурын үндсэн дээр оруулах ба үнэлгээнд эерэгээр нөлөөлөх боломжтой.
- Гэр бүлийн чөлөө, цэргийн болон цэргийн бус алба хаасан, бусад чөлөө, ажил мэргэжлийн завсарлага, огноо, үргэлжилсэн хугацаа сараар

8. Судалгааны санхүүжилт, тэтгэлэг

- Судалгааны томоохон санхүүжилт: санхүүжилтийн эхлэл, төгсгөлийн хугацаа, санхүүжилтийн төрөл, эх үүсвэр, хэмжээ; судалгааны багийн санхүүжилтийн өргөдөл бэлтгэхэд гүйцэтгэсэн үүрэг; төслийн удирдагчийн/голлох судлаачийн нэр

9. Судалгааны ажлын үр дүн

- Нийт өгүүлэл, нийтлэлийн тоо, мөн хамгийн чухал болон/эсвэл хамгийн их ишлэгдсэн арван бүтээл (мэдээллийн санг заах); нээлттэй хандалт бүхий бүтээлийн холбоос; **бүтээлийн жагсаалтыг БШУЯ-ны Дээд Боловсролын Зөвлөлийн ангиллаар ангилан тусад нь хавсаргах**
- Боловсруулсан арга зүй, программ хангамж, дэд бүтэц, материал, гарын авлага, зааварчилгаа, хэрэгслүүд
- Патент, зохион бүтээсэн шинэ бүтээл
- Хамгийн чухал урлагийн ажил, боловсруулалт

10. Судалгааны ажлын удирдагч болон манлайллын туршлага

- Албан ёсоор томилогдсон бакалавр болон ахисан түвшний зэргийн оюутнуудын диплом, эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажилласан байдал: зэргийн хөтөлбөр тус бүрээр удирдсан тоо болон үндсэн удирдагч, хамтран удирдагчийг ялгах
- Судалгааны баг эсвэл төсөл удирдсан туршлага (ажлын нарийвчилсан тодорхойлолт, жишээ нь докторын дараах судлаачийг дагалдуулан ажиллах, гм)

11. Багшийн ажлын чадахуйн үзүүлэлт

- Багшлах ажлын чадахуйг анхааралтай сонгож, байгаа зүйлсээ тодорхой танилцуулах хэрэгтэй. Шаардлагатай бол багшлах ажлын чадахуйн үзүүлэлтийг тусад нь сургалтын ажлын үр дүнгийн багцад харуулж болно.
- Сурган хүмүүжүүлэх, багшлах эрхийн сургалтад хамрагдсан, бусад нотлогдсон сурган хүмүүжүүлэх, багшлах туршлага
- Сургалт, заах аргын судалгаанд суурилсан, хамтын хөгжүүлэлт (жишээ нь сургалтын материал боловсруулах, нээлттэй сургалтын материалаар хангах, хөгжүүлэлтийн багт ажиллах, сурган хүмүүжүүлэхийн бүтээлүүд)
- Ерөнхий багшлах ажлын туршлага
- Сургалт хөгжүүлэлтэд зориулж авсан санхүүжилт

12. Шагнал, хэргэм цол

- Шинжлэх ухаан, урлаг, эрдэм шинжилгээ, мэргэжлийн чиглэлээр гаргасан амжилт болон эрдмийн салбарт ажилласан хөгжил, дэвшилд зориулсан хүртсэн шагнал, өргөмжлөл, хэргэм цол
- Сургалтын чиглэлээр олгосон мэргэжлийн өргөмжлөл, үнэмлэх/Recognition of teaching

13. Бусад эрдмийн чадахуйн үзүүлэлтүүд, тухайлбал

- Докторын диссертацийн шүүмжлэгчээр ажиллах; докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнчлэл
- Ажлын сонгон шалгаруулалтын болон эрдмийн цол олгох өргөдлийн үнэлгээний шинжээч
- Төслийн санхүүжилтийн өргөдлийн бие даасан шинжээч
- Шинжлэх ухааны нийгэмлэгийн гишүүнчлэл, итгэлцлийн албан тушаал
- Үндэсний болон олон улсын шинжээчийн, үнэлгээний, удирдах (steering) багийн гишүүнчлэл, бусад шинжээчийн үүрэг (судлаач өөрийн шинжлэх ухааны судалгааны чиглэлээр үнэлгээний ажилд оролцох, гэх мэт)
- Шинжлэх ухаан, мэргэжлийн сэтгүүл, цувралын редакцын зөвлөлийн гишүүн, редактор, ерөнхий редактор
- Эрдэм шинжилгээний өгүүллийн шүүмжлэгч
- Дээд боловсрол, судалгааны байгууллагын удирдлагын, ажлын албаны албан тушаал, дээд боловсролын хүрээний нийгэмлэгийн ажил, албан тушаал, шинжлэх ухаан, судалгааны удирдлагын үндэсний болон олон улсын итгэлцлийн албан тушаал (Жишээлбэл, ёс зүйн хорооны)
- Нэр хүндтэй олон улсад уригдсан лекцүүд
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах

14. Шинжлэх ухаан, нийгмийн нөлөөлөл

- Нээлттэй шинжлэх ухаан, судалгааг түгээн дэлгэрүүлэх, тухайлбал, судалгааны материал, өгөгдөл бүтээх, хариуцлагатайгаар түгээх
- Судалгааны үр дүнг ашиглах (өөрийн болон бусдын)
- Судалгааны ажлыг хариуцлагатай гүйцэтгэх явдлыг дэлгэрүүлэх, тухайлбал судалгааны шударга байдлын зөвлөхөөр ажиллах гм
- Хариуцлагатай судалгаа шинжилгээ, инновацын үйл ажиллагааг хөгжүүлэх
- Шинжээчийн албан тушаал болон хүлээсэн үүрэг, итгэлцлийн гол албан тушаал
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй түршлагатай мэргэжилтний хуваарь судалгааны талаар холбоотой ажиллах, хэвлэлээр гарах

15. Бусад чадвар

- CV-ний зорилготой хамааралтай бусад албан тушаал, хүлээсэн үүрэг хариуцлага (компани, байгууллагад ажилласан байдал, гэх мэт)
- Бусад нийгмийн ажлын чадахуйн үзүүлэлт, нэр хүндийн өргөмжлөл;
- CV-ний зорилгод хамааралтай бусад түршлага, чадвар